



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 567

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан технологийн сангийн харьяа Уул уурхайн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон, 17,250,000.00 (арван долоон сая хоёр зуун тавин мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Шинжлэх ухаан технологийн сангийн захирал Д.Одгэрэл, Уул уурхайн хүрээлэнгийн захирал Х.Жаргалсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төсөвт төвлөрүүлсэн баримт, худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны... дүгээр сарын...-ны өдрийн
567 дугаар тогтоолын хавсралт

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САНГИЙН ХАРЬЯА УУЛ УУРХАЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН
ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Сэргээн босголтын зардал	Худалдах доод үнэ
				/төгрөг/		
1	М Пажеро 6732 УБЛ. суудлын арал:V74200519	1996/2005	314266	17,250,000.00	0	1,500,000.00
НИЙТ ҮНЭ				17,250,000.00	-	1,500,000.00
НИЙТ ҮНЭ				(арван долоон сая хоёр зуун тавин мянга)		(нэг сая таван зуун мянга)